



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**УИХ-ын Төрийн байгуулалтын
Байнгын хорооны саналын дагуу хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлан**

**Улс төрийн намуудад төсвөөс
олгосон мөнгөн дэмжлэг
санхүүжилтийн үр дүн**

**Орон нутгийн төсвөөс улс төрийн намуудад
санхүүжилт олгосон нь хууль, эрх зүйн
үндэслэлгүй**

Агуулга

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын Нэгдүгээр газар

Газрын захирал

Д.Ганбилэг

Аудитын менежер

Ж.Батсайхан

Ахлах аудитор

Л.Одгэрэл

Аудитор

А.Сүхбаатар

Шинжээч

Ц.Эрдэнэчулуун

2007 оны 10 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын
Веб сайтаас үзнэ үү:

www.mnao.pmis.gov.mn

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Засгийн газрын 4 дүгээр байр,
Бага тойруу-6, Улаанбаатар-46
Монгол Улс

Агуулга.....2

Товчилсон үгсийн жагсаалт 4

Бүлэг 1

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1.1 Аудит хийсэн үндэслэл.....5

1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ.....5

1.3 Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт,
хугацаа.....5

Бүлэг 2

Орон нутгийн төсвөөс улс төрийн намуудад санхүүжилт олгосон нь хууль, эрх зүйн үндэслэлгүй байна

2.1 Улсын төсвөөс олгох санхүүжилтийн хэмжээг хууль бусаар нэмэгдүүлжээ.....7

2.2 Улс төрийн намуудад санхүүжилтийг хуваарийн дагуу олгожээ.....7

2.3 Улс төрийн намуудын санхүүжилтийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн хяналтгүй олгож байна.....8

2.4 УИХ дахь намын суудлын тоо өөрчлөгдөхөд санхүүжилтийг зохицуулж олгожээ.....8

2.5 УИХ-д бие даан нэр дэвшиж сонгогдсон гишүүдэд УДШ-ийн тогтоолыг үндэслэн үлдэгдэл санхүүжилтийг олгоогүй байна.....9

2.6 Орон нутгийн төсвөөс ИТХ-д суудалтай улс төрийн намуудад санхүүжилт олгосон нь хууль бус байна.....9

2.7 Орон нутгийн төсвөөс зарим намд санхүүжилт олгоогүй буюу илүү, дутуу олгосон, өөр байгууллагад өгсөн байна.....11

Бүлэг 3

Улс төрийн намууд төсвөөс олгосон хөрөнгийг хуулийн дагуу зарцуулаагүй байна

3.1 Улс төрийн намууд санхүүжилтийг хуваарийн дагуу авчээ.....12

3.2 Улс төрийн намууд УИХ-ын гишүүдийн тойрогт зарцуулах төсвийн хөрөнгийг бүрэн зарцуулаагүй байна.....12

3.3 Орон нутгийн төсвөөс улс төрийн намуудад хууль зөрчиж олгосон хөрөнгийг ч зохистой зарцуулж чадаагүй байна.....13

ДҮГНЭЛТ.....15

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....17

ТАЙЛБАР.....20

ЗӨВЛӨМЖ.....21

Хавсралт №1

Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
УДШ	Улсын Дээд Шүүх
МАХН	Монгол ардын хувьсгалт нам
АН	Ардчилсан нам
ИЗН	Иргэний зориг нам
ЭОН	Эх орон нам
БНН	Бүгд найрамдах нам
ҮШН	Үндэсний шинэ нам
АТН	Ард түмний нам
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
СӨХ	Сууц өмчлөгчдийн холбоо
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Бүлэг 1

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1.1 Аудит хийсэн үндэслэл

Аудитыг УИХ-ын Төрийн байгуулалтын Байнгын хорооны санал, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2007 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ

Улс төрийн намуудад төсвөөс олгосон санхүүжилтийн үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийлээ.

1. Улс төрийн намуудад улсын төсвөөс олгосон хөрөнгийг хуулийн дагуу санхүүжүүлсэн эсэх,
2. Улс төрийн намуудад төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт

Аудитаар УИХ-ын Тамгын газар, Сангийн яамнаас улс төрийн намуудад санхүүжилт олгосон журнал, дансны хуулга, УИХ -д суудалтай улс төрийн намуудын 2005-2006 оны санхүүгийн тайлан, бусад холбогдох баримт материалыг шалгав.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-д суудалтай улс төрийн намуудад орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт, холбогдох шийдвэр, олгосон санхүүжилтийг зохих журмын дагуу зарцуулсан эсэх асуудлыг нэмэлт төлөвлөгөөний дагуу шалгав.

1.3 Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа

Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

- Монгол Улсын 2005 оны төсвийн тухай хууль,
- Монгол Улсын 2006 оны төсвийн тухай хууль,

- Улс төрийн намын тухай хууль,
- Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль,
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль,
- Улс төрийн намын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай Монгол Улсын Дээд шүүхийн 2006 оны 48 дугаар тогтоол,
- Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон холбогдох бусад хууль, тогтоомж

Аудитыг Үндэсний аудитын газрын Нэгдүгээр газрын захирал Д.Ганбилэг удирдаж, аудитын менежер Ж.Батсайхан аудитын явцад хяналт тавьж, Төсөв, санхүү, банк, өр зээлийн багийн ахлах аудитор Л.Одгэрэл, аудитор А.Сүхбаатар, шинжээч Ц.Эрдэнэчулуун нар 2007 оны 8 дугаар сарын 27-ноос 10 дугаар сарын 24-ний өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-д суудалтай улс төрийн намуудад орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийн үр дүнг Аймаг, нийслэлийн аудитын газрууд 2007 оны 10 дугаар сарын 3-наас 15-ны өдрүүдэд шалгав.

Бүлэг 2 Орон нутгийн төсвөөс улс төрийн намуудад санхүүжилт олгосон нь хууль, эрх зүйн үндэслэлгүй байна

2.1 Улсын төсвөөс олгох санхүүжилтийн хэмжээг хууль бусаар нэмэгдүүлжээ

2005-2006 оны төсвийн төлөвлөгөөнд улс төрийн намуудад улсын төсвөөс олгох санхүүжилтийг УИХ-ын гишүүний 1 суудлыг 2005 онд 2.5 сая төгрөгөөр тооцон 190,0 сая төгрөг, 2006 онд 10,0 сая төгрөгөөр тооцон 760,0 сая төгрөгөөр төлөвлөжээ.

Улс төрийн намын тухай 1990 оны хуульд 1996 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар "... Улсын Их Хурлын гишүүний нэг суудлыг жилд нэг сая төгрөгөөр тооцож, Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд улирал тутам санхүүжилт олгоно. Энэхүү хэмжээг мөнгөний ханшийн өөрчлөлтийг харгалзан өөрчлөн тогтоож байна" гэсэн өөрчлөлт оруулжээ. Санхүүжилтийн энэ хэмжээг өөрчилсөн ямар нэгэн шийдвэр гараагүй байхад 2001 оноос УИХ-ын нэг суудлыг 2,5 сая төгрөгөөр тооцон улсын төсөвт тусган улс төрийн намуудыг санхүүжүүлсэн нь хууль бус үйлдэл болжээ.

2005 онд шинэчлэн баталсан Улс төрийн намын тухай хуулийн 19.1-д "Улсын Их Хурлын сонгуулиар тухайн намын авсан саналыг нийт хүчинтэй саналын тоотой харьцуулах зарчмаар нэг саналыг мянган төгрөгөөр тооцож, сонгуулийн дүн гарсны дараа гурван сарын дотор багтаан Улсын Их Хуралд суудал бүхий намд төр нэг удаа мөнгөн дэмжлэг үзүүлнэ", 19.2-т "Улсын Их Хуралд суудал бүхий намд түүний авсан суудлын тоогоор Улсын Их Хурлын гишүүний нэг суудлыг жилд арван сая төгрөгөөр тооцож, Улсын Их Хурлын тухайн бүрэн эрхийн хугацаанд улирал тутам улсын төсвөөс санхүүжилт олгоно. Энэ санхүүжилтийн 50 хувийг Улсын Их Хурлын гишүүдийн сонгуулийн тойрогт явуулах үйл ажиллагаанд зарцуулна" гэж заажээ.

Дээрх хуулийн 19.1 дэх заалт 2008 оны УИХ-ын сонгуулиас эхлэн хэрэгжих учир улс төрийн намуудад төрөөс мөнгөн дэмжлэг олгоогүй байна.

Мөн хуулийн 19.2 дахь заалтыг үндэслэн УИХ-д суудалтай улс төрийн намуудад 2005-2006 онд улсын төсвөөс 875,0 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

2.2 Улс төрийн намуудад санхүүжилтийг хуваарийн дагуу олгожээ

Сангийн яам улс төрийн намуудад УИХ дахь суудлын тоогоор улсын төсвөөс улирал бүр санхүүжилт олгосон бөгөөд ингэхдээ төрийн аль нэг байгууллагаас УИХ дахь улс төрийн намуудын суудлын тоог тодорхойлуулж аваагүй байна.

Харин УИХ-д суудалтай улс төрийн намуудын удирдах албан тушаалтны албан бичгийг үндэслэн санхүүжилтийг намуудад шууд олгожээ.

Намуудад улсын төсвөөс олгосон санхүүжилтийг хүснэгтээр харуулбал:

д/д	Намын нэр	2005 он		2006	
		Суудлын тоо	Санхүүжилт /мян.төг/	Суудлын тоо	Санхүүжилт /мян.төг/
1	МАХН	36	90 000,0	38	377 500,0
2	Ардчилсан нам	25	62 500,0	25	222 500,0
3	Иргэний зориг нам	2	5 000,0	2	20 000,0
4	Бүгд найрамдах нам	1	2 500,0	1	10 000,0
5	Эх орон нам	7	17 500,0	7	52 500,0
6	Бие даагч гишүүн			3	15 000,0
		71	177 500,0	76	697 500,0

2005 онд маргаантай байсан 2 тойрог болон бие дааж нэр дэвшсэн 3 гишүүний суудалд төсвөөс санхүүжилт олгоогүй байна.

Сангийн яам улс төрийн намуудад олгох 2006 оны 4 дүгээр улирлын санхүүжилт 175,0 сая төгрөгийг УИХ-ын Тамгын газарт шилжүүлсэн бөгөөд УИХ-ын Тамгын газар улс төрийн намуудад 112,5 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Улс төрийн намын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай УДШ-ийн 48 дугаар тогтоол 2006 оны 10 дугаар сарын 30-нд гарч, энэ тогтоолын 8 дугаар заалт, УИХ-ын гишүүдийн намын гишүүнчлэлд гарсан шилжилтийг үндэслэн 62,5 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй Сангийн яаманд буцаан төвлөрүүлжээ.

2.3 Улс төрийн намуудын санхүүжилтийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн хяналтгүй олгож байна

УИХ улс төрийн намуудад 2005, 2006 онд төсвөөс олгох санхүүжилтийг УИХ-ын төсвийн багцад оруулан баталсан тул УИХ-ын Тамгын газраар дамжин олгогдох ёстой.

Гэтэл УИХ-ын Тамгын газар энэ санхүүжилт УИХ-аас нийлүүлэх бүтээгдэхүүн биш тул УИХ-аар дамжуулан санхүүжүүлэх эрх зүйн үндэсгүй байна гэж үзэн УИХ-ын Төсвийн Байнгын хороонд ханджээ. УИХ-ын Төсвийн Байнгын хорооны дарга Ч.Улаан улс төрийн намын санхүүжилтийг Сангийн яамнаас шууд санхүүжүүлэх саналыг 2007 оны 9/923 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлжээ.

Үүний улмаас Сангийн яам улс төрийн намуудад олгох санхүүжилтийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн хяналтгүйгээр намуудад шууд олгож байна.

УИХ-д суудал бүхий улс төрийн намууд улсын төсвөөс олгосон санхүүжилт, түүний зарцуулалтын талаархи тайланг Сангийн яаманд гаргаж ирүүлээгүй байна.

2.4 УИХ дахь намын суудлын тоо өөрчлөгдөхөд санхүүжилтийг зохицуулж олгожээ

2005 онд УИХ-ын гишүүн Л.Гүндалай АТН байгуулан АН-аас гарснаас өөр намын гишүүнчлэлийн шилжилт гараагүй байна.

Улс төрийн намуудад олгох 2006 оны эхний 3 улирлын санхүүжилтийг УИХ-ын гишүүдийн намын гишүүнчлэлийн шилжилтийг харгалзахгүйгээр олгосон байна.

2006 онд УИХ-ын гишүүн Ц.Батаа ЭОН-ын гишүүнээс татгалзаж МАХН-д гишүүнээр элссэн, УИХ-ын гишүүн О.Энхсайхан 2006 оны 3 дугаар сарын 24-нд нас барсан, УИХ-ын гишүүн М.Энхсайхан, Ж.Наранцацралт, Ж.Батхуяг, О.Сономпил нар АН-ын гишүүнээс татгалзаж ҮШН байгуулан гишүүнээр элссэн, УИХ-ын гишүүн Х.Баттулга, Х.Эрдэнэбүрэн нар ЭОН-ын гишүүнээс татгалзаж АН-д гишүүнээр элссэн, УИХ-ын нөхөн сонгуульд МАХН-аас нэр дэвшсэн Ө.Энхтүвшин УИХ-ын гишүүнээр сонгогдсон зэргээс УИХ дахь намуудын суудлын тоо өөрчлөгдсөн байна.

Улс төрийн намын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай УДШ-ийн 2006 оны 48 дугаар тогтоолын 8-д "... Нам буюу намын эвслээс нэр дэвшсэн нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон бөгөөд Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаандаа тухайн намаас гарч, өөр намын гишүүн болсон тохиолдолд түүний нэрийг дэвшүүлсэн намын Улсын Их Хурал дахь суудлын тоо хасагдах ба шинээр элссэн намд суудлын тоо нэмэгдэхгүй ..." гэж заасны дагуу ЭОН-аас гарч МАХН-д элссэн гишүүний суудлын 5,0 сая төгрөг, АН-аас гарч Үндэсний шинэ намын гишүүнээр элссэн 4 гишүүний суудлын 30,0 сая төгрөг, ЭОН-аас АН-д элссэн гишүүний суудлын 2,5 сая төгрөг, АН-аас гарч Ард түмний нам байгуулан гишүүнээр элссэн 1 гишүүний суудлын 10,0 сая төгрөгийг олгоогүй байна.

Ерөнхийлөгчөөр сонгогдсон болон нас барсан УИХ-ын гишүүдийн тойрогт 2006 онд нөхөн сонгууль болж, маргаантай байсан 2 тойргоос сонгогдсон гишүүний бүрэн эрхийг зөвшөөрснөөр УИХ бүрэн бүрэлдэхүүнээр ажиллажээ.

2.5 УИХ-д бие даан нэр дэвшиж сонгогдсон гишүүдэд УДШ-ийн тогтоолыг үндэслэн үлдэгдэл санхүүжилтийг олгоогүй байна


Бие даан нэр дэвшин УИХ-ын гишүүн болсон Р.Амаржаргал, Д.Одхүү, Я.Санжмятав нарын суудлын санхүүжилтийн 50 хувь буюу 15,0 сая төгрөгийг УИХ-ын Тамгын газрын дансанд Сангийн яамны Төрийн сангаас шилжүүлснийг УИХ-ын Төсвийн зарлагын дэд хорооны дарга З.Энхболдын 2006 оны 4 дүгээр сарын 21-ний 8/2464 дугаар албан бичиг болон УИХ-ын 3 гишүүний хүсэлтийг үндэслэн 2006 оны 4 дүгээр сарын 27-нд Орхон аймгийн АН-д, 2006 оны 5 дугаар сарын 19-нд Завхан аймгийн АН-д, 2006 оны 6 дугаар сарын 29-нд Баянгол дүүргийн АН-ын 9 дүгээр үүрт тус бүр 5,0 сая төгрөг шилжүүлжээ.

Улс төрийн намын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай УДШ-ийн 2006 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 48 дугаар тогтоолын 8-д "... Аль нэг намын гишүүн намаасаа биш харин өөрөө бие дааж нэрээ дэвшүүлж, Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон бөгөөд намын гишүүнчлэлээ хадгалсан эсхүл өөр намын гишүүн болсон тохиолдолд түүний гишүүнчлэлээ хадгалж байгаа нам болон шинээр гишүүнээр элссэн намын алинд ч Улсын Их Хурал дахь суудлын тоо нэмэгдэхгүй..." гэж заасны дагуу бие даан нэр дэвшсэн 3 гишүүний суудлын үлдэгдэл 15,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй байна.

2.6 Орон нутгийн төсвөөс ИТХ-д суудалтай улс төрийн намуудад санхүүжилт олгосон нь хууль бус байна

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын шийдвэрээр ИТХ-д суудалтай улс төрийн намуудад 2000-2006 онд орон нутгийн төсвөөс 1,8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгожээ. /Дэлгэрэнгүй судалгааг хавсралтаар үзүүлэв./

ИТХ-д суудалтай улс төрийн намуудад орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтэд намуудын эзлэх хувийг графикаар харуулбал:



Улс төрийн намын тухай хуульд улс төрийн намуудад орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох тухай заалт байхгүй.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ 1992 оны Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1.1-д “нутаг дэвсгэрийн ... төсөв...” батлах, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 50.1.2-т “тухайн жилийн орон нутгийн төсвийг хэлэлцэн батлах”, мөн хуулийн 58.3-т “Тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчийн Хурал, Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийн төслийг 1 сарын дотор хэлэлцэн батална” гэж заасныг үндэслэн ИТХ-ын төлөөлөгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг санхүүжүүлэх зорилгоор ийм шийдвэр гаргажээ.

Энэ шийдвэр нь 1990 онд батлагдсан Улс төрийн намын тухай хуулийн 12 дугаар зүйлийн “ Улсын Их Хуралд суудал бүхий намд авсан суудлын тоог баримтлан ... санхүүжилт олгоно”, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 6.2-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, ... г төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна” гэж заасныг зөрчсөн байна. Энэ хуулийн 18.1-д орон нутгийн ИТХ-ын УИХ болон төрийн эрх бүхий бусад байгууллагад хуулиар харьяалуулсан асуудлыг шийдвэрлэх эрхийг хязгаарласан байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25.5-д “Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй” гэж заасны дагуу ИТХ-д суудалтай улс төрийн намуудад орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох аймаг, нийслэлийн ИТХ-ын шийдвэрийг эргэж харах арга хэмжээг УИХ-аас авч хэрэгжүүлээгүй байна.

Зарим аймаг, сум, дүүрэг ИТХ-ын шийдвэргүйгээр орон нутгийн төсөвт намын санхүүжилт нэрээр хөрөнгө мөнгө тусган, ИТХ-ын нэг суудалд олгох санхүүжилтийг 2-3 жилийн давтамжтайгаар нэмэгдүүлжээ. ИТХ-ын нэг суудалд жилд олгох санхүүжилтийг аймаг, нийслэл, сум, дүүргүүдэд харилцан адилгүй тогтоосон ба 2006 оны байдлаар сумд 20,0-30,0 мянган төгрөг, аймагт 250,0-300,0 мянган төгрөг, дүүрэгт 500,0 мянган төгрөг, нийслэлд 1,0 сая төгрөг байна.

2.7 Орон нутгийн төсвөөс зарим намд санхүүжилт олгоогүй буюу илүү, дутуу олгосон, өөр байгууллагад өгсөн байна

Орон нутгийн төсөвт тусгагдсан намын санхүүжилтийг олгох тодорхой журам байхгүй бөгөөд жилд 1-2 удаа олгосон байна. Ингэхдээ зарим тохиолдолд харилцан адилгүй хандаж, илүү, дутуу санхүүжилт олгосон байна. Тухайлбал:

- Нийслэлийн төсвөөс 2001-2004 онд БНН-д 4000,0 мянга, 2005 онд АН-д 2000,0 мянга, мөн бие даагч гишүүний 2000,0 мянга, Сэлэнгэ

аймгийн төсвөөс 2006 онд МАШСН-д 250.0 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус олгоогүй байна.

- 2001-2002 онд Багануур дүүргийн АН, МАХН-д 1800,0 мянга, Хөвсгөл аймгийн төсвөөс 2003-2004 онд МАХН-д 600.0 мянга, 2005-2006 онд АН-д 500.0 мянга, Хэнтий аймгийн төсвөөс 2003-2006 онд МАХН-д 309.0 мянга, АН-д 1813.4 мянга, Төв аймгийн төсвөөс АН-д 2005 онд 250.0 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус дутуу олгожээ.
- Хөвсгөл аймгийн төсвөөс 2005 онд МАХН-д 187.0 мянга, Баянхонгор аймгийн төсвөөс 2006 онд АН-д 300.0 мянга, Сэлэнгэ аймгийн төсвөөс 2000-2004 онд МАХН-д 2250.0 мянга, АН-д 1340.0 мянга, Төв аймгийн төсвөөс МАХН-д 2002 онд 300.0 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус илүү олгожээ.
- Сонгино хайрхан дүүргийн ИТХ 2002-2006 онд МАХН-д олгох 17635,0 мянган төгрөгийн санхүүжилтийг олголгүй өөрөө зарцуулахаар авсан байна.
- Улс төрийн намуудад олгох санхүүжилтээс 2005-2006 онд Өмнөговь аймгийн ИТХ 4950,0 мянга, 2001-2006 онд Говьсүмбэр аймгийн ИТХ 15865,0 мянган төгрөгийг ИТХ-ын төлөөлөгч нарт намын байгууллагаар дамжуулалгүй шууд олгосон байна.
- 2005 онд Баянзүрх дүүргийн АН-д олгох 500,0 мянган төгрөгийг "ТБТЭ" ХХК-д, Баянзүрх дүүргийн ЭОН-д олгох 500,0 мянган төгрөгийг "Сансар" СӨХ-д, 2006 онд Баянзүрх дүүргийн ЭОН-д олгох 500,0 мянган төгрөгийг "Мандах нар" СӨХ-д, Чингэлтэй дүүргийн АН-д олгох 500,0 мянган төгрөгийг "Цогт интернэшнл" ХХК-ийн дансанд тус тус шилжүүлжээ.

Бүлэг 3 Улс төрийн намууд төсвөөс олгосон хөрөнгийг хуулийн дагуу зарцуулаагүй байна

3.1 Улс төрийн намууд санхүүжилтийг хуваарийн дагуу авчээ

УИХ-д суудалтай улс төрийн намууд улсын төсвөөс 2005 онд 177,5 сая төгрөгийн, 2006 онд 697,5 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарийн дагуу бүрэн авчээ.

Улс төрийн намууд улсын төсвөөс авсан хөрөнгийг данс бүртгэлд тусган санхүүгийн тайлангаар тайлагнасан байна.

3.2 Улс төрийн намууд УИХ-ын гишүүдийн тойрогт зарцуулах ёстой төсвийн хөрөнгийг бүрэн зарцуулаагүй байна

2005 онд улс төрийн намуудад УИХ дахь нэг суудлыг 2,5 сая төгрөгөөр тооцож, 177,5 сая төгрөгийн санхүүжилт олгосныг намууд өөрийн үйл ажиллагаандаа зарцуулжээ.

Улс төрийн намын тухай шинэчлэн найруулсан хуулийн 19.2-т "...Улсын Их Хурлын гишүүний нэг суудлыг жилд арван сая төгрөгөөр тооцож, санхүүжилтийн 50 хувийг Улсын Их Хурлын гишүүдийн сонгуулийн тойрогт явуулах үйл ажиллагаанд зарцуулна" гэж заасан. 2006 онд УИХ-д суудалтай улс төрийн намуудын улсын төсвөөс авсан санхүүжилтээс УИХ-ын гишүүдийн сонгуулийн тойрогт зарцуулсан байдлыг хүснэгтээр харуулбал:

				/мян.төг/
д/д	Намын нэр	Тойрогт олгох	Олгосон	Зөрүү
1	МАХН	188 750,0	76 860,0	-111 890,0
2	АН	111 250,0	69 002,8	-42 247,2
3	ИЗН	10 000,0		-10 000,0
4	БНН	5 000,0		-5 000,0
5	ЭОН	26 200,0	29 800,0	3 600,0
6	Бие даагч	15 000,0	15 000,0	
	Дүн	356 200,0	190 662,8	-165 537,2

Хүснэгтээс үзвэл улсын төсвөөс олгосон санхүүжилтээс хуулийн дагуу УИХ-ын гишүүдийн тойрогт 356,2 сая төгрөг зарцуулахаас 190,7 сая төгрөг зарцуулжээ. Үүнд:

- МАХН 2006 оны улсын төсвийн санхүүжилтийн 50 хувь болох 188,7 сая төгрөгийн санхүүжилтээс УИХ-ын 20 гишүүнд тойрогтоо ажиллах үйл ажиллагаанд зориулж бэлнээр 76,9 сая төгрөг олгожээ. УИХ-ын гишүүд тойрогтоо зарцуулсан хөрөнгийн зарцуулалтын тайланг гаргаж өгөөгүй байна. УИХ-ын гишүүдийн тойрогт зарцуулах 111,8 сая төгрөгийн санхүүжилтийг хуулийн дагуу зарцуулаагүй бөгөөд намын үйл ажиллагааг санхүүжүүлжээ.
- АН 2006 онд УИХ-ын гишүүдийн сонгогдсон тойргийн Архангай, Баян-Өлгий, Өвөрхангай зэрэг 12 аймаг, Баянзүрх, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн АН-ын хороодод 69,0 сая төгрөгийг намын санхүүжилт нэрээр шилжүүлжээ. Үлдэх 42,2 сая төгрөгийн санхүүжилтийг тус намаас 2006 онд зохион байгуулсан хурал, семинар, хичээл зэрэг нэгдсэн арга хэмжээнүүд болон тус онд хуралдсан намын үндэсний 3 дугаар их чуулганы УИХ-ын гишүүдийн тойргоос сонгогдсон төлөөлөгчдийн зардалд зарцуулсан гэж АН-ын удирдлага тайлбарлаж байна. Дээрх арга хэмжээнд зарцуулсан санхүүгийн баримт байгаа боловч УИХ-ын гишүүдийн тойргоос хэдэн төлөөлөгч оролцсон, түүнд хэдэн төгрөг зарцуулсан тодорхой тооцоо алга байна.
- 2006 онд ИЗН, БНН улсын төсвөөс олгосон санхүүжилтийг намын үйл ажиллагаандаа зарцуулж, УИХ-ын гишүүдийн тойрогт зарцуулаагүй байна.
- ЭОН-аас сонгогдсон УИХ-ын гишүүд тойрогтоо ажиллахдаа төсвийн санхүүжилтээс 29,8 сая төгрөгийг бэлнээр авч зарцуулсан байна.

Намууд төсвийн хөрөнгийг УИХ-ын гишүүдийн тойрогт хэрхэн зарцуулах асуудал журамлагдаагүй байна.

АН УИХ-ын гишүүдийн сонгуулийн тойрогт шилжүүлсэн хөрөнгийн, МАХН УИХ-ын гишүүдэд бэлнээр олгосон хөрөнгийн зарцуулалтын тайлан гаргаагүй байна.

3.3 Орон нутгийн төсвөөс улс төрийн намуудад хууль зөрчиж олгосон хөрөнгийг ч зохистой зарцуулж чадаагүй байна

Орон нутгийн төсвөөс улс төрийн намуудад хууль зөрчиж олгосон хөрөнгийг зарцуулах асуудал ч журамлагдаагүй байна. Иймээс:

- Улс төрийн намд олгох санхүүжилтээс ИТХ-ын төлөөлөгч нарт бэлнээр олгосон, өөр байгууллагын дансанд шилжүүлсэн, санхүүжилтийн үр дүн тодорхой бус, зарцуулалт нь санхүүгийн тайланд тусгагдаагүй зэрэг зохисгүй байдал гарсан байна.
- Сонгино хайрхан дүүргийн ИТХ 2002-2006 онд МАХН-д олгох 17635,0 мянган төгрөгийг ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, бичиг

хэргийн зүйлс авах, зөвлөлийн гишүүдэд урамшуулал өгөх, шинэ жилийн болон аяллын арга хэмжээнд зарцуулжээ.

- Хан-Уул дүүргийн МАХН-ын хороо 2002-2006 онд орон нутгийн төсвөөс авсан 86,0 сая төгрөгөөр барилга барьжээ.
- Өмнөговь аймгийн ИТХ улс төрийн намуудад ИТХ дахь 1 суудалд олгох 300,0 мянган төгрөгөөр тооцон санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн боловч энэ санхүүжилтийн 100,0 мянган төгрөгийг нь ИТХ-ын төлөөлөгч нарт олгожээ.
- Говьсүмбэр аймгийн ИТХ орон нутгийн төсвөөс улс төрийн намуудад олгох санхүүжилтээр сан байгуулан, энэ сангаас тодорхой хэсгийг нь ИТХ-ын төлөөлөгч нарын намд шилжүүлж, үлдэх хэсгийг нь ИТХ-ын төлөөлөгч нарын сонгуулийн тойрогт ажиллах зардалд олгожээ.
- 2006 онд Баян-Өлгий аймгийн АН-д олгосон 6.0 сая төгрөгийн санхүүжилтээс 660.0 мянган төгрөгийг аймгийн ИТХ-ын төлөөлөгчийн эмчилгээний зардалд зарцуулсан байна.
- Хэнтий аймгийн ИТХ-аас 2003 онд улс төрийн намуудад 8450.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон гэж тайлагнасан боловч 1050.0 мянган төгрөгийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн гадаад арга хэмжээний зардал, албан томилолт, бэлэг дурсгалын зүйлд зарцуулжээ.
- Орон нутгийн төсвөөс ИТХ-д суудалтай улс төрийн намуудад олгосон хөрөнгийн зарцуулалтын анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, данс бүртгэлд дутуу тусгасан, санхүүгийн тайланг олон улсын стандарт, зарчимд нийцүүлж тайлагнаагүй байна.

Дүгнэлт

Улс төрийн намуудад төсвөөс олгосон мөнгөн дэмжлэг, санхүүжилтийн үр дүнд хийсэн аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- 1990 оны Улс төрийн намын тухай хуульд 1996 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар "... Улсын Их Хурлын гишүүний нэг суудлыг жилд нэг сая төгрөгөөр тооцож, ... санхүүжилт олгоно" гэсэн өөрчлөлт оруулсан. Харин 2001 оноос УИХ-ын нэг суудлын санхүүжилтийг 2,5 сая төгрөг болгон нэмэгдүүлэхдээ хуульд холбогдох өөрчлөлт оруулаагүй байна.
- УИХ дахь улс төрийн намуудын суудлын тоог төрийн аль нэг байгууллагаас Сангийн яаманд баталгаажуулж өгөөгүй байна. Улс төрийн намуудад улсын төсвөөс 2005, 2006 онд олгох санхүүжилтийг УИХ-ын төсвийн багцад оруулан баталсан боловч УИХ-ын Тамгын газар энэ санхүүжилтийг УИХ-аар дамжуулах эрх зүйн үндэсгүй байна гэж үзсэн учир Сангийн яам уг санхүүжилтийг намуудын удирдах албан тушаалтны албан бичгийг үндэслэн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хяналтгүйгээр намуудад шууд олгож байна.
- Улс төрийн намын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай УДШ-ийн 2006 оны 48 дугаар тогтоолын 8-д "... Аль нэг намын гишүүн намаасаа биш харин өөрөө бие дааж нэрээ дэвшүүлж, Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон бөгөөд намын гишүүнчлэлээ хадгалсан эсхүл өөр намын гишүүн болсон тохиолдолд түүний гишүүнчлэлээ хадгалж байгаа нам болон шинээр гишүүнээр элссэн намын алинд ч Улсын Их Хурал дахь суудлын тоо нэмэгдэхгүй..." гэж заасны дагуу бие дааж нэр дэвшсэн 3 гишүүний суудлын 15,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй байна.
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-д суудалтай улс төрийн намуудад орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох тухай ИТХ-ын шийдвэр хууль, эрх зүйн үндэслэлгүй байна.
- 2006 онд УИХ-ын гишүүдийн тойрогт зарцуулах хөрөнгөөс МАХН 111,9 сая төгрөгийг, АН 42,2 сая төгрөгийг тус тус дутуу зарцуулсан, ИЗН, БНН огт зарцуулаагүй нь Улс төрийн намын тухай хуулийн 19.2-т "... санхүүжилтийн 50 хувийг Улсын Их Хурлын

гишүүдийн сонгуулийн тойрогт явуулах үйл ажиллагаанд зарцуулна” гэж заасныг зөрчсөн байна.

- Орон нутгийн төсвөөс ИТХ-д суудалтай улс төрийн намуудад хууль зөрчиж олгосон санхүүжилтийг зарцуулах асуудал журамлагдаагүй, санхүүжилтийг зарим намд олгоогүй буюу илүү, дутуу олгосон, өөр байгууллагад өгсөн, ИТХ өөрөө дур мэдэн зарцуулсан, ИТХ-ын төлөөлөгч нарт шууд олгосон, зориулалт бусаар зарцуулсан, нягтлан бодох бүртгэлд дутуу тусгасан, санхүүгийн тайланг хууль, тогтоомжийн дагуу тайлагнаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Холбогдох байгууллагын санал

УИХ-ын Тамгын газар



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

210646 Улаанбаатар хот, Төрийн ордон
Сүхбаатарын талбай 6, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: secretariat@mail.parl.gov.mn
http://www.parl.gov.mn

2007. 11. 06, № 3/927

танай _____-ны № _____-т

Аудитын тайлангийн төсөлд
өгөх санал

Улс төрийн намуудад төсвөөс олгосон монгол дэмжлэг, санхүүжилтийн үр дүнд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

Улс төрийн намын тухай хуулийн 19.2-т "Улсын Их Хуралд суудал бүхий намд түүний авсан суудлын тоогоор арван сая төгрөгөөр тооцож, Улсын Их Хурлын тухайн бүрэн эрхийн хугацаанд улирал тутам улсын төсвөөс санхүүжилт олгоно" гэж заасан. Хуулийн энэхүү зүйл заалтад санхүүжилтийг Улсын Их Хурлаас олгох тухай заагаагүй. Гэтэл 2005 оны УИХ-ын төсвийн багцад улс төрийн намуудын дэмжлэгт батлагдсан санхүүжилт УИХ-ын дансанд орж ирэхгүйгээр түүгээрээ Сангийн яам олгож байсан. Иймээс бид 2006 оны төсөвт улс төрийн намуудын дэмжлэгийг УИХ-ын төсвийн багцаас гарган тусад нь тусгаж, Сангийн яам түүгээрээ олгож байх нь зүйтэй болох талаар албан бичгээр Сангийн яаманд удаа дараа хандаж байсан болно.

Гэвч 2006 оны Улсын төсөвт УИХ-ын төсвийн багцад дээрхи хөрөнгийг урьдын адил тусгаж баталсан бөгөөд санхүүжилтийг Сангийн яам түүгээрээ олгож ирсэн юм. Харин 2006 оны 4 дүгээр улиралд олгогдох дэмжлэгийн 175 сая төгрөгийг Сангийн яамнаас Улсын Их Хурлын Тамгын газрын дансанд оруулсныг тухайн үед гарсан Улсын дээд шүүхийн тайлбарын дагуу улс төрийн намуудад шилжүүлж, олгогдох ёсгүй хөрөнгийг Сангийн яаманд буцаасан юм.

00000000

Энэ асуудлыг нэг мөр болгон журамлах үүднээс УИХ-ын Төсвийн байнгын хорооны даргад танилцуулж, албан бичгээр мэдэгдсэний дүнд энэхүү санхүүжилтийг Сангийн яам одоо ч эрхлэн гүйцэтгэж байгаа билээ.

Иймд Аудитын дүгнэлт, зөвлөмжид улс төрийн намуудад олгох санхүүжилтийн хөрөнгийг цаашид УИХ-ын төсвийн багцаас гаргаж, Сангийн сайдын төсвийн багцад тусган, санхүүжүүлж байх талаар тодорхой зааж өгөхийг хүсье. УИХ-ын 2006 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, зөвлөмжид ч энэ талаар тодорхой чиглэл өгөгдсөн билээ.



ЕРӨНХИЙ НАРИЙН
ВИЦГИЙН ДАРГА

Н.ЛУВСАНЖАВ

Сангийн яам

Тайлбарыг 20
дугаар
хуудаснаас үзнэ
үү.



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

210545 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нагдсан үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: 26-02-47, <http://www.mof.gov.mn>

2007. 11.07 № 7-9/5124
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

Улс төрийн намуудад төсвөөс олгосон мөнгөн дэмжлэг, санхүүжилтийн үр дүнд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Гарсан санал дүгнэлт, зөвлөмжид дараах тайлбар, саналыг өгч байна. Үүнд:

1. Сангийн яам Монгол Улсын 2001 оны төсвийн төслийг УИХ-д өргөн барихдаа УИХ-д суудалтай улс төрийн намуудад улсын төсвөөс олгох санхүүжилтийг тооцохдоо УИХ-ын гишүүний нэг суудлыг 1.0 сая төгрөгөөр тооцсон. Харин төсвийн хэлэлцүүлгийн явцад улс төрийн шийдвэр гарч УИХ-ын нэг суудлын санхүүжилтийг 2.5 сая болгон нэмэгдүүлж, энэ нь "Монгол Улсын 2001 оны төсвийн тухай хууль"-иар батлагдсаны дагуу манай яам санхүүжүүлсэн юм. Иймд аудитын тайланд дээрх асуудлыг бодитойгоор тайлбарлан, цаашид УИХ-ын холбогдох байнгын хороонд энэ асуудлыг дахин давтан гаргахгүй байхыг зөвлөмж болгох;
2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын хувьд УИХ-ын даргын төсвийн багцад тусган тухайн жилийн төсвийн тухай хуулиар батладаг. Гэтэл УИХ-ын Тамгын газар энэ санхүүжилт УИХ-аас нийлүүлэх бүтээгдэхүүн биш гэж үздэг. Улс төрийн намуудын санхүүжилт нь бусад төсвийн ерөнхийлөн захирагчийн бүтээгдэхүүнд хамаарагдах үндэслэлгүй тул аль төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад тусгах нь зүйтэй болох талаар зөвлөмжид тодорхой зааж өгнө үү. Тү айлбал, УИХ-ын даргын төсвийн багцад тусгах гэх мэт;
3. Улс төрийн намын тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай УДШ-ийн 48 дугаар тогтоолын хүрээнд намууд болон бие даан нэр дэвшигчдэд 2005, 2006 онуудад улсын төсвөөс намуудын дэмжлэгийг дутуу олгосон нь зөв зүйтэй эсэхэд тодорхой хариу өгсөн дүгнэлт хийх нь зүйтэй гэж үзэж байна. Мөн зөвлөмжийн хэсэгт УДШ-ийн 48 дугаар тогтоолыг цаашид хэрхэн ханган ажиллах талаарх зөвлөмжийг нэмж тусгуулах;
4. "Улс төрийн намын тухай хууль"-ийн 20.1-т "намын санхүүгийн үйл ажиллагаанд тухайн намын хяналтын байгууллага хяналт тавина" гэж заасан тул улс төрийн намуудад олгосон санхүүжилтийг зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах журмыг Сангийн сайд батлан, мөрдүүлэх үндэслэлгүй байна. Иймд "Улс төрийн намуудад төсвөөс олгосон санхүүжилтийг зарцуулах, гүйцэтгэлийг нь тайлагнах журмыг баталж, мөрдүүлэх" гэсэн зөвлөмжийг мөн хүлээн авах боломжгүй бөгөөд хуулинд өөрчлөлт оруулах шаардлага гарна.



Ч.ГАНЗОРИГ
Ч.ГАНЗОРИГ

08 4872

Тайлбар

Сангийн яамнаас ирсэн саналд дараах тайлбарыг хийж байна. Үүнд:

1. 2005 онд шинэчлэгдсэн Улс төрийн намын тухай хуулийн 19.2-т “Улсын Их Хуралд суудал бүхий намд түүний авсан суудлын тоогоор Улсын Их Хурлын гишүүний нэг суудлыг жилд арван сая төгрөгөөр тооцож, Улсын Их Хурлын тухайн бүрэн эрхийн хугацаанд улирал тутам улсын төсвөөс санхүүжилт олгоно...” гэж заасан учир УИХ-ын холбогдох Байнгын хороонд зөвлөмж өгөх шаардлагагүй гэж үзлээ.

2. УИХ-д суудалтай улс төрийн намуудад улсын төсвөөс олгох санхүүжилтийг Төсвийн аль нэг ерөнхийлөн захирагчийн төсвийн багцаар дамжуулан олгож, зарцуулалтыг нь зохих журмын дагуу тайлагнаж байх асуудлыг судалж шийдвэрлэх талаар УИХ-ын Төрийн байгуулалтын Байнгын хорооны даргад зөвлөмж өгсөн бөгөөд энэ асуудлыг шийдвэрлэх нь тус Байнгын хорооны эрх үүрэг билээ.

3. УДШ-ийн 48 дугаар тогтоолыг хэрхэн ханган ажиллах нь танай яамны үйл ажиллагаа тул зөвлөмж өгөх боломжгүй.

4. Сангийн сайдад улс төрийн намуудад төсвөөс олгосон санхүүжилтийг зарцуулах, гүйцэтгэлийг нь тайлагнах журмыг баталж, мөрдүүлэх талаар өгсөн зөвлөмж нь зөвхөн улсын төсвөөс олгосон санхүүжилтэд хамаарах бөгөөд энэ нь Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 8.1.4-т “санхүү, төсвийн удирдлагын асуудлаар өөрийн эрх хэмжээний хүрээнд заавар, журам батлан гаргах” гэсэн заалттай нийцэж байгаа билээ.

Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

УИХ-ын Төрийн байгуулалтын Байнгын хорооны дарга Л.Дондогт:

- УИХ-д суудалтай улс төрийн намуудад улсын төсвөөс олгох санхүүжилтийг Төсвийн аль нэг ерөнхийлөн захирагчийн төсвийн багцаар дамжуулан олгож, зарцуулалтыг нь зохих журмын дагуу тайлагнаж байх асуудлыг судалж шийдвэрлэх,
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-д суудалтай улс төрийн намуудад орон нутгийн төсвөөс санхүүжилт олгож буй асуудлын хууль эрх зүйн үндэслэлийг судалж, холбогдох арга хэмжээ авах,

Сангийн сайд Н.Баяртсайханд:

- Улс төрийн намуудад улсын төсвөөс олгох санхүүжилтийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцаар дамжуулан олгож байх санал боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх,
- Улс төрийн намуудад төсвөөс олгосон санхүүжилтийг зарцуулах, гүйцэтгэлийг нь тайлагнах журмыг баталж, мөрдүүлэх

Улс төрийн намуудад орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийн судалгаа

№	Нийслэл, аймгийн нэр	Сум, дүүргийн төсвөөс 2000-2006 онд олгосон санхүүжилт						Аймаг, нийслэлийн төсвөөс 2000-2006 онд олгосон санхүүжилт						/мянган-төгрөг/	
		МАХН	АН	ЗОН	ИЗН	бие даалч	БНН	Дүн	МАХН	АН	ЗОН	ИЗН	бие даалч		БНН
1	Архангай	6522	6508	80	20			13130	28950	18300					47250
2	Баян-Өлгий							0	29000	11330	2800	2100			45230
3	Баянхонгор							0	18500	8400	1500	750			29150
4	Булган							0	46900	4750	650				52300
5	Говь-Алтай							0	9000	6000					15000
6	Говьсүмбэр							0	14260	1143					15403
7	Дархан-Уул	18464.5	5050	200		160		23874.5	24208.3	7291.7					31500
8	Дорноговь							0	28300	1200	1200	1200			31900
9	Дорнод	17200	2600			200		20000	28750	5750	750	2250			37500
10	Дундговь							0	33900	17100					51000
11	Завхан							0	52296.2	6978.5	989.1				60263.8
12	Орхон							0	27000	6000	600	600			34200
13	Өвөрхангай							0	20600	6200		600	600		28000
14	Өмнөговь							0	7311.6	2883.6		300			10495.2
15	Сүхбаатар							0	20000	17500					37500
16	Сэлэнгэ							0	34350	13440.9	250		800		48840.9
17	Төв	15880	9035.9					24915.9	33902.2	9250	1600				44752.2
18	Увс	2280	880	330	60			3550	38950	6450	2350				47750
19	Ховд							0	35440.7	7050	1781.2	500			44771.9
20	Хөвсгөл	1606.1						1606.1	22337.4	10200	1550	500	1000		35687.4
21	Хэнтий							0	17241	10436.6	1248.4				28926
22	Улаанбаатар	62202.8	37567.2	8833.7	7667.2	1067.2		3833.7	721071.8	2000					231667
		724155.4	61641.1	9443.7	7647.2	1427.2		3833.7	808148.3	179654.3	17268.7	5200	6000	0	1006987.4

№	Нийслэл, аймгийн нэр	Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийн дүн									
		МАХН	АН	ЗОН	ИЗН	Биле даагч	БНН	Дүн			
1	Архангай	35472	24808	80	20	0	0	60380			
2	Баян-Өлгий	29000	11330	2800	0	2100	0	45230			
3	Баянхонгор	18500	8400	1500	750	0	0	29150			
4	Булган	46900	4750	650	0	0	0	52300			
5	Говь-Алтай	9000	6000	0	0	0	0	15000			
6	Говьсүмбэр	14260	1143	0	0	0	0	15403			
7	Дархан-Уул	42672.8	12341.7	200	0	160	0	55374.5			
8	Дорноговь	28300	1200	1200	0	1200	0	31900			
9	Дорнод	45950	8350	750	2250	200	0	57500			
10	Дундговь	33900	17100	0	0	0	0	51000			
11	Завхан	52296.2	6978.5	989.1	0	0	0	60263.8			
12	Орхон	27000	6000	600	600	0	0	34200			
13	Өвөрхангай	20600	6200	0	600	600	0	28000			
14	Өмнөговь	7311.6	2883.6	0	0	300	0	10495.2			
15	Сүхбаатар	20000	17500	0	0	0	0	37500			
16	Сэлэнгэ	34350	13440.9	250	0	800	0	48840.9			
17	Төв	49782.2	18285.9	1600	0	0	0	69668.1			
18	Увс	41230	7330	2880	60	0	0	51300			
19	Ховд	35440.7	7050	1781.2	500	0	0	44771.9			
20	Хөвсгөл	23943.5	10200	1550	500	1000	0	37193.5			
21	Хэнтий	17241	10436.6	1248.4	0	0	0	28926			
22	Улаанбаатар	891869.8	39567.2	8833.7	7567.2	1067.2	3833.7	952738.8			
		1525019.8	241295.4	26712.4	12847.2	7427.2	3833.7	1817135.7			

Судалгааг нэгтгэсэн:

ҮАГ-ын аудитор

А.Сүхбаатар



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2007 оны 11 сарын 09 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг.Улс төрийн намуудад төсвөөс олгосон мөнгөн дэмжлэг, санхүүжилтийн үр дүнд хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.

Хоёр.Аудитын тайланг УИХ-ын Төрийн байгуулалтын Байнгын хороо, Сангийн яаманд хүргүүлсүгэй.

Гурав.Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2008 оны 5 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг УИХ-ын Төрийн байгуулалтын Байнгын хорооны дарга Л.Дондог, Сангийн сайд Н.Баяртсайхан нарт зөвлөсүгэй.

Дөрөв.Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын 1 дүгээр газрын захирал Д.Ганбилэгт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Л.ЖАВЗМАА

Хуулбар үнэн:



С.Лхагвасүрэн
С.ЛХАГВАСҮРЭН

070239